

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

|   |                       |                     |           |
|---|-----------------------|---------------------|-----------|
| Ярилцлага өгөгчийн нэр                              | Хоролсүрэн            | Дугаар              | L186      |
| Оршин суугаа аймаг                                  | Говь-Алтай аймаг      | Оршин суугаа сум    | Дарви сум |
| Төрсөн газар  | Дарви сум             | Төрсөн он           |           |
| Ажил мэргэжил                                       | Өндөр настан          |                     |           |
| Лам байсан эсэх,<br>Шавилан сууж байсан сүм<br>хийд | Дархан гүний хурал    | Сүм хийдийн дугаар  | ГАДР 110  |
| Одоогийн сүм хийд                                   |                       | Сүм хийдийн дугаар  |           |
| Ярилцлага авсан он сар<br>өдөр                      | 2007 оны 8-р сарын 29 | Ярилцлага авсан хүн | Мөнхнасан |



Говь-Алтай аймгийн Дарви сумын Дархан гүний хурал

Асуулт:- Ингээд тус сумын нутагт байсан Дархан гүний хурлын тухай та бидэнд ярьж өгнөүү. Хаана байсан юм бэ?

Хариулт:-Байшингийн ар жалгаар байсан байхаа. Дархан гүний хурал.

Асуулт:-Хэд орчим **лам хуврагатай** байсан юм бэ?

Хариулт:-Дархан гүний дацан чинь Тонхилын хүрээг бодвол цөөхөн байсан. 60, 70-аад улс байсан байхаа.

Асуулт:-Тэргүүлж байсан том ламын нэр алдрыг мэдэх үү?

Хариулт:-Чогдон тойн, Дондов тойн гэсэн Дархан гүний **дацангийн** том том лам нар байсан. Чогдон тойн, Дондов тойн их том том лам нар байсан.

Асуулт:-Дархан гүний **дацангийн** гол шүтээн нь ямар бурхан байв?

Хариулт:-Гол шүтээн нь Улаан сахиус байсан

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-60 орчим ламтай байсан юм байна?

Хариулт:-Тийм.

Асуулт:-Тэнд **жод, лүйжин тавьдаг** лам нар байсан уу? улааны урсгалын шашны?

Хариулт:-Мэдэхгүй, байгаагүй байхаа.

Асуулт:-Барилга **байшингий** нь бүрэн бүтэн байхад нь та харж байсан уу?

Хариулт:-Би чинь хойгуур нутагтай, тэнд л тийм юм гэлцээд байдаг, нэг сайн ч мэдэхгүй л байгаа юмаа, тэр **байшингий нь**.Овоо нь том сайхан 13 сан тавьдаг, эргэн тойрон тийм чулуун овоо нь одоо болтол байж байдаг юм байна лээ.Тэр овоо нь тэр их цагаан газар хаанаас л том чулуу авчирч овоолдог юм, гэрийн чинээ том овоо байдаг юм.

Асуулт:-Тэр овоогоо **тахидаг** байсан уу? лам нар.

Хариулт:-Тахидаг байсан

Асуулт:-Хэдэн сард тахидаг байсан юм, зун тахидаг байсан уу?

Хариулт:-Зуны сард л, мацаг өдөр 15. Бүтэн шөнийн 8-нд л тахидаг байсан юм даа.

Асуулт:-Яаж тахидаг байсан юм бол?

Хариулт:-Хэнгэрэг цантай, **агдог, намдагсан** гэсэн тийм сангууд уншаад **цогчид**өргөөд тэгж л тахидаг байсан даа.

Асуулт:-Цагаан идээ, шүүсээр тахидаг байсан уу?

Хариулт:-Цагаан идээ, шүүсээр л тахина.

Асуулт:-Наадам болдог байв уу, овоо тахиад?

Хариулт:-Наадам ч барилдаж хийдэггүй байсан байхаа.

Асуулт:-Хийдэд **Ганжуур, Данжуур** гээд том судар байсан уу?

Хариулт:-Байлгүй **яахав**. Ганжуур, **данжуур** хоёр л лав байсан.

Асуулт:-Цам **Майдар** гардаг байв уу?

Хариулт:-Гарахгүй ээ.

Асуулт:-Дацанд ном судраа **барладаг** бар байсан уу, хуучны.

Хариулт:-Дархан гүний дацанд чухам юу байсан юм, байсан байлгүй дээ.

Асуулт:-60 гаруй ламтай байсан гэсэн?

Хариулт:-60 гаруй ламтай байсан юм.

Асуулт:-Хятадын худалдаачид байсан уу? тэр хавиар

Хариулт:-Байлгүй **яахав**, зөндөө л байсан.

Асуулт:-Монголчуудаас арьс шир түүхий эдийг нь аваад.

Хариулт:-Арьс шир, түүхий эд, тэгэхэд чинь юм бүгд авдаг байсан шүү, ишигний арьс юм бүгд л авдаг байсан даа.

Асуулт:-Дархан гүний **дацангийн** лам нар өөр ямар уул овоо тахидаг байсан бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Дархан гүнийхээ овоог тахихаас биш өөр овоо тахиагүй байхаа.

Асуулт:-Та тэр үед хийдэд шавилж ном үзэж байсан уу?

Хариулт:-Би тэгэхэд жаахан байсан.

Асуулт:-Хэдэн настайдаа та хийдэд шавилж суусан?

Хариулт:-18-тай суув уу даа.

Асуулт:-Хэр удаан суусан?

Хариулт:-26 настай дом тавьсан.

Асуулт:-Та гэвш хүн үү?

Хариулт:-Би нэг тоонд явж л байсан.

Асуулт:-Хэдэн жил сураад дом тавих вэ?

Хариулт:-60, 70 улс байдаг юм.

Асуулт:-Зиндаагаар ном унших уу?

Хариулт:-8 жил дээрээ дом тавьдаг тийм л байсан юм.

Асуулт:-Та тэгээд дом тавьдаг байсан уу?

Хариулт:-Тавьсан.

Асуулт:-Тэгвэл та чинь гэвш хүн юм байна шүү дээ. Тэр үед та цуг ном үзэж байсан хүүхдүүдийнхээ тухай, багш нарынхаа тухай ярьж өгөхгүй юу? яаж ном үздэг байсан.

Хариулт:-Багшдаа шавилаад ном заалгаад яваад байдаг, тийм л юм ном заалгадаг тийм л байсан юм.

Асуулт:-**Дүйр**үзэж байсан уу? Чойрын ном шүү дээ.

Хариулт:-Чойрын ном хойно үзэж байсан л даа.

Асуулт:-Танай дацанд Түвд, Энэтхэгээс Чойрын ном заадаг багш нар байв уу?

Хариулт:-Байгаагүй байхаа, Тонхилын хүрээний их гэвш дээр мянган ламтай дацан байсан шүү дээ, Тонхилын хүрээ чинь. Тэндээс **Дондогсайхан** гэвш гэж их эрдэмтэй гэвш байсан л даа.**Усан зүйлийн** хүрээний лам нар гэж нэртэй тийм л юм байсан юм.

Асуулт:-Таны Чойр зааж байсан багш монгол хүн байв уу?

Хариулт:-Монгол

Асуулт:-Энэ хүрээний том лам байсан уу?

Хариулт:-Тийм.

Асуулт:-Алдар нэрийг нь хэлж болохгүй байх даа.

Хариулт:-Болохгүй.

Асуулт:-37 оны үед танай багш байсан уу?

Хариулт:-Байсан

Асуулт:-Хэлмэгдэлтийн үед баригдсан уу?

Хариулт:-Баригдсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Чойр аль **игчаагаар** үзэж байсан бэ? **Гүнчин игчаагаар** үзэж байсан уу? Сэр **игчаагаар** үзэж байсан уу?

Хариулт:-**Гүнчин игчаагаар** үзэж байсан байхаа.

Асуулт:-Таны багш их алдартай хүн байсан уу? Танай багш нар гавж хүмүүс байсан уу?

Хариулт:- Гавж байлгүй **яахав**.

Асуулт:-Гүнгийн хүрээнд Энэтхэг, Түвдээс хүүхдүүд ирж ном үздэг байв, Чойр эд нар.

Хариулт:-Үгүй байхаа, энэ дээр л очдог байсан.

Асуулт:-Танай зиндаа 60 орчим хүүхэдтэй байсан уу?

Хариулт:-70 орчим хүүхэдтэй байсан юм

Асуулт:-Ганцхан зиндаа нь уу?

Хариулт:-Тийм

Асуулт:-Тэгээд 70 зиндаагаар 7, 8 зиндаа гэхээр чинь их олон ламтай байсан байна шүү.

Хариулт:-Тиймээ, яриа байхгүй. Эхлээд яахад 80 ч хүрдэг л юм, тэгээд сүүлдээ 70 хавьд явж л байсан, тэрнээс хар болоод үхэж үрэгдээд 60, 70 дом тавьдаг тийм л байсан.

Асуулт:-Та тэр үеийн **гэсгүй** ламынхаа тухай ярьж өгнөүү, хэн гэдэг хүн байсан?

Хариулт:-**Нүүнээжавин** багш гэж өндөр тушаалтай тийм багш байсан. Баруун хүрээний нэг сайхан багш байсан.**Цугаарангий** нь аваад явж л байсан даа.

Асуулт:-Та дом тавьсан тухайгаа ярьж өгөхгүй юу?

Хариулт:-Дом тавих Ногоон дарь эх, хэнхэг татуулдаг дом их урт л даа. Дом тавихад шажин ч сайхан байлаа.

Асуулт:-Хэдэн онд дом тавьсан юм бэ?

Хариулт:-Эрт байхаа.

Асуулт:-1936 онд дом тавьсан юмуу?

Хариулт:-Тэгсэн байхаа, би тэр он сарыг нь ч мэдэхгүй юм. Тэр хавьд л тавьсан байх.

Асуулт:-Дарь эх татаад л .

Хариулт:-Ногоон дарь, 42 морьтой, ногоон дарь эх, цагаан дарь эх татаж хурдаг дом тийм л юм байсан юм даа.

Манай Зүйлийн хийд чинь том дацан байсан юм шүү дээ.Энэ дээр чаддаг нь л дом тавиад, тэр л ян татуулаад.Ян татдаг улс их байсан.Иш багш гэж байсан, Намжилжав багш гэж байсан, **Нүүрнээжав** багш гэж байсан.Эд нар дандаа **маниуст** л ном татаж зааж өгдөг тийм багш нар байсан юм л даа. Тэгээд засаг төр эвгүйтээд тэр улс ч яваадөглөө,тэгээд **бид** ингээд хоцорчихсон юм.

Асуулт:-Та дом тавихдаалам захтай дээл өмсөж байв уу?

Хариулт:-Өмсөж байсан. Цугаараа лам захтай байлаа.

Асуулт:-Шар торгон дээл үү, хүрэн торгон дээл байх уу?

Хариулт:-Шар торгон дээл. Орхимж гэж нэг их улаан юм удирдчихдаг, шашир гэж нэг тийм тэмээний үсэн малгай өмсөөд тэгээд байдаг их сайхан л даа.Тэр цагтаа сайхан л юм байсан юм тэр чинь.

Асуулт:-Чойр дацандаа л домын зиндаа барих уу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Тэгнэ.

Асуулт:-Домын зиндаа барихаар чинь лам нар гаднаас орж ирдэг шүү дээ, танай зиндааныхан. Тэгэхээр **гэсгүй** нь гэрээдээд оруулдаг билүү, утаа тавиад.

Хариулт:-Ариун сан гээч юм л

Асуулт:-**Гэсгүй**нь оруулах үү?

Хариулт:-Зүгээр л орчихно.

Асуулт:-Танай зиндааны **жорвонг** хэн гэдэг хүн байсан бэ?

Хариулт:-**Чойндонжав** гэдэг хүн байсан юм. Байхгүй ээ, одоо.

Асуулт:-Хэлмэгдэлтийн үед байхгүй болов уу, дараа нь өндөр наслаад.

Хариулт:-Хэлмэгдэлтээр явж Завхан дээр 10 жил **болчихоод** хүрч ирээд, тэгээд Улаанбаатарт нас барсан.

Асуулт:-10 жил ял эдэлсэн гэсэн үг үү?

Хариулт:-Ял эдэлсэн.

Асуулт:-Чойндон **жорвон** гэдэг хүн байсан юмүү?

Хариулт:-Тийм. Зүйлийн хүрээнд их ном үздэг манай зиндааны **жорвон** байсан шүү дээ. **Жорвон** гэж хамгийн толгой хүнийг л хэлдэг байсан шүү дээ.

Асуулт:-Зүйлийн хүрээ чинь хуучны засаг захиргааны **хуваариар** аль аймаг, аль хошуу вэ?

Хариулт:-Баруун Засагт хан аймаг, Дайчин бэйсийн хошуу гэж байсан.

Асуулт:-Хэлмэгдэлтийн үед барилга, байшин бурхан шүтээн нь яасан юм бол?

Хариулт:-Мэдэхгүй, зарж үрж алга хийсэн юмуу, ачсан юмуу, улс л аваачсан юм гэдэг тийм л үг байдаг юм. Том том их **хөлгөнүүд**, 108 боть сандал шиг том зузаан боть **номнууд** байсан, 108 ширхэг.Тэрнийг яаж далд хийсэн юм, хэн авсан юм, хэн **мэдэхэв**.

Асуулт:-Барилга **байшингий** нь түүхий тоосгоор барьсан байсан уу? Зүйлийн хүрээний.

Хариулт:-Тиймээ. Түүхий тоосго байсан.

Асуулт:-Монголчууд барьсан уу?

Хариулт:-Монголчууд л барьсан биз дээ, дээр үеийн. Би мэдэхгүй.

Асуулт:-Анх Зүйлийн хүрээг анх ямар хошууны ноён зарлигаар ч гэдэг юмуу үүсгэж бий болгосон юм бол?

Хариулт:-Дайчин бэйсийн хошуу гэж байсан юм.**Цогчэн дуган** гээд 4 өнцгөөс нь 4 том хонх дүүжилчихсэн. Үргэлж жингэнэж байдаг.Хоёр давхар, дээрээ нэг дугантай.Цогчэн дуган шиг тийм том юм, тэрнийг музейд үлдээчих нь **яваа**.Тэр мөн сайхан эд байсан шүү, 3 хаалгатай.Тэгээд л байхгүй.

Асуулт:-Гурван хаалга гэдэг чинь урдаа нэг, баруун зүүндээ нэг нэг гэсэн үг үү?

Хариулт:-Үгүй дээ, урд талдаа л 3 хаалгатай. Зэрэгцүүлээд 3 хаалга гаргачихсан.

Асуулт:-Зүйлийн хүрээ зулын 25-ны үеэр ямар хурал ном хурдаг байсан юм бол?

Хариулт:-Зулын 25 гэдэг чинь зул шатаагаад, зулын 25-ны 4 зүйл гэж байсан юм, ном хурдаг байсан юм даа, ямар ном хурж байсан билээ.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-36 онд дом тавьж байсан дээл, хувцас байгаа юу?

Хариулт:-Яаж **байхав**, байхгүй, алга болсон.

Асуулт:-Дарви сумын нутагт байсан Дархан гүний хүрээний талаар та мэдэх үү?

Хариулт:-Сайн мэдэхгүй ээ.

Асуулт:-Та Зүйлийн хүрээн дээр хурал ном хурж байгаад гэвшийн дамжаа бариад тэгээд шашин байхгүй болсон юм байна шүү дээ.

Хариулт:-Тэгсэн.